# ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ТАМГЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин (Эхний хагас жил) | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилго 1. Даатгуулагчийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн цахим тогтолцоог бэхжүүлнэ.** | | | | | | | |
| Зорилт 1.4.Салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгоно. | | | | | | | |
| 1.4.1 | БГТ-1.4.3<br>Эрүүл мэндийн салбарын багц хуулийн өөрчлөлт, шинэчилсэн найруулгад санал хүргүүлнэ. | - | Хүргүүлсэн саналын тоо | Ахмад настны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал хүргүүлсэн. | Салбарын багц хууль тогтоомжийн өөрчлөлт, шинэчилсэн найруулгад санал хүргэгдсэн байна. | Эрүүл мэндийн салбарын 33 хуульд дүн шинжилгээ хийж, Донорын тухай хууль, Эрхтэн эд эс шилжүүлэн суулгах тухай хуулийн 2 төсөлд санал хүргүүллээ.<br>***Үр дүн:*** Холбогдох газарт ЭМДЕГ-ын санал хүргэгдсэн. | 100 |
| 1.4.2 | Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулга хийх ЭМЯ-ны ажлын хэсэгтэй хамтран ажиллаж, санал хүргүүлнэ. | - | Хүргүүлсэн саналын тоо | ЭМДтХ-ийн шинэчлэн найруулсан төсөлд 22 санал хүргүүлсэн. | ЭМДЕГ-ын даргын тушаалаар дотооддоо ажлын хэсэг байгуулан ажиллуулж, санал хүргүүлсэн байна. | Тайлант хугацаанд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн зүйл, заалт бүрийг судлаад өөрчлөн найруулах 7, нэмж оруулах 10, хасах 7 нийт 24 санал боловсруулаад байна. ЭМДЕГ-ын даргын 2025 оны А/08 дугаар тушаалаар дотоодын ажлын хэсгийг байгуулж, салбарын хууль, эрх зүйн орчинд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж ажиллалаа.<br>***Үр дүн:*** Саналыг боловсруулж ажлын хэсэгт хүргүүлэхэд бэлэн болсон. | 80 |
| 1.4.3 | Эрүүл мэндийн даатгалын байгууллагын хууль эрх зүйн орчинд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, зөрчил, хийдлийг арилгана. | - | Хяналт шинжилгээний дүн | Шинээр болон шинэчлэн 18 журам, 4 аргачлал, 2 дүрмийг батлан мөрдөн ажиллаж байна. | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дотоодод мөрдөгдөх дүрэм, журмыг хуульд нийцүүлсэн байна. | Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд хяналт, шинжилгээ үнэлгээ хийж батлагдвал зохих 14 журам, 2 дүрэм 1 төсөв батлахаар хуульчилсан боловч 2 журам батлагдаагүй байна. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар ЭМДБ-ын хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийн хувь 96.3 хувь, огт хэрэгждэггүй 3 зүйл, 3 заалт байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ***Үр дүн:*** ЭМДтХуулийн зүйл заалтад дүн шинжилгээ хийж, хуульд нийцүүлсэн байна. | |
| 1.4.4 | Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах гэрээний бүртгэл хөтлөх, шинээр болон шинэчлэн боловсруулах, санал, зөвлөмж өгөх, эрх зүйн үндэслэлийг хуульд нийцүүлэн хянах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | - | Гэрээний тоо, хуулийн үндэслэл | 233 гэрээ байгуулж ажилласан. | Гэрээний эрх зүйн үндэслэлийг хуульд нийцүүлэн хянаж, бүртгэл хөтөлсөн байна. | 2025 оны хагас жилийн байдлаар хамтран ажиллах гэрээ 56, ажил гүйцэтгэх гэрээ 23, худалдах, худалдан авах гэрээ 1, хөлсөөр ажиллах гэрээ 2, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулах зуучлалын гэрээ 1, ажлын байр түрээслэх гэрээ 1, нийт 84 гэрээнд эрх зүйн үндэслэлийг хуульд нийцүүлэн хянаж, санал зөвлөмж өгч гэрээний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.<br>***Үр дүн:*** Гэрээний эрх зүйн үндэслэлийг 84 удаа хуульд нийцүүлэн хөтлөх үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. | 100 |
| 1.4.5 | Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу сонсох ажиллагаа явуулах, тайлбар, нотлох баримт цуглуулах, дүгнэлт бичиж зохих шийдвэрийг гаргуулна. | - | Сонсох ажиллагааны тоо | 22 сонсох ажиллагаа явуулж, 6 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан байна. | Сонсох ажиллагааг хуулийн хүрээнд явуулж шийдвэрлэсэн байна. | Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу 8 албан хаагчид сонсох ажиллагааг явуулж, тайлбар, нотлох баримт цуглуулах ажиллагааг холбогдох хууль журмын хүрээнд зохион байгууллаа. Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам зэргийг үндэслэн 1 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулж хариуцлага хүлээлгэсэн.<br>***Үр дүн:*** Сонсох ажиллагааг хуулийн хүрээнд явуулж шийдвэрлэсэн. | 100 |
| 1.4.6 | Шүүх, хууль хяналтын байгууллагад байгууллага, албан тушаалтныг төлөөлөх, мэдээлэл, нотлох баримт бүрдүүлэх, тайлбар гаргах, хамтран ажиллах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | - | Тайлант хугацаанд хамтран ажилласан тохиолдлын тоо | 1044 хэрэгт төлөөлөн оролцсон. | Байгууллага, албан тушаалтныг төлөөлөн оролцож, | Нийслэл, дүүргийн цагдаагийн байгууллагын 458 эрүүгийн хэрэгт иргэний нэхэмжлэгчээр, шүүхийн байгууллагад иргэний хэргийн хариуцагчаар 3, нэхэмжлэгчээр 2, захиргааны шүүхэд хариуцагчаар 1 хэрэгт тус тус цахимаар болон биечлэн төлөөлөн оролцож нийт 464 хэрэгт тайлбар мэдүүлэг өгч, холбогдох нотлох | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хамтран ажилласан байна. | баримтыг гаргаж өгсөн байна. Шүүхийн шийдвэрийг хангуулах зориогоор Сүвэн-Уул ХХК-ийн нэхэмжилсэн 174,740,000 төгрөг, Аюурвэйд ХХК-ийн нэхэмжилсэн 187,480,000 төгрөгийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэж, ЭМД-ын санд учирсан гэм хорын хохирол болох 8,253,900 төгрөгийг хариуцагч ЭМДСанд нөхөн төлүүлэхээр шүүхийн шийдвэр гарсан.<br>***Үр дүн:*** Хууль хяналтын байгууллагатай 464 удаа байгууллагаа төлөөлөн оролцож хамтран ажиллалаа. | |
| 1.4.7 | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын төв, орон нутгийн ажилтнуудыг хууль зүйн зөвлөгөө, мэдээллээр хангаж, эрх зүйн туслалцаа үзүүлнэ. | - | Эрх зүйн туслалцаа үзүүлсэн албан хаагчдын тоо | Тайлант хугацаанд 225 албан хаагчид хууль эрх зүйн мэдээлэл, зөвлөгөөгөөр хангаж ажилласан. | Хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, эрх зүйн туслалцаа үзүүлж ажилласан байна. | Тайлант хугацаанд ЭМДтХуулийн 12.1.1-т заасны дагуу төв, орон нутгийн 160 албан хаагчдад цахим уулзалт зохин байгуулж хууль эрх зүйн зөвлөгөө мэдээлэл өглөө.<br>***Үр дүн:*** 160 албан хаагчдад хууль эрх зүйн мэдээлэл, зөвлөгөө өгсөн. | 100 |
| 1.4.8 | Зөрчил шалган шийдвэрлэх болон Төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, холбогдох байгууллагатай хамтран ажиллана. | - | Арга зүйгээр хангасан тохиолдлын тоо | 117 гомдол мэдээллийг бүртгүүлж, 20 гомдол шийдвэрлэсэн байна. | Хуулийн хэрэгжилт хангагдсан байна. | 2025 он гарснаар Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг зохион байгуулаагүй ба гомдол хүлээн аваагүй байна. Мөн Нийслэлийн Прокурорын газрын Хяналтын прокурортой хамтран зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан хаагчдад “Зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулахад анхаарах асуудал” сэдэвт сургалт, “Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан”-ийн хэрэглэгч нарт зориулсан сургалтад байгууллагын эрх бүхий албан тушаалтнуудыг бүрэн хамруулж мэдээллээр хангах ажлыг зохион байгууллаа.<br>***Үр дүн:*** Зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулах, гомдол мэдээлэл хүлээн авч хянах, шалгах мэдлэг дээшилсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.4.9 | Эрүүл мэндийн даатгалын байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүрэг, бодлогын зорилт, дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд тулгуурлан ЭМДЕГ-ын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж, батлуулна. | - | Батлагдсан төлөвлөгөө | 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталсан. | 2025 оны 01 дүгээр сард гүйцэтгэлийн төлөвлөгөө батлагдсан байна. | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2025 оны төлөвлөгөөг байгууллагын 2023-2026 оны стратеги төлөвлөгөө, бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан 4 зорилго 11 зорилтын хүрээнд 70 арга хэмжээ төлөвлөн боловсруулж, 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдөр Эрүүл мэндийн сайдаар батлуулсан.<br>***Үр дүн:*** ЭМДЕГ-ын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө батлагдсан. | 100 |
| 1.4.10 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн бүртгэл хөтлөх, шинэчлэх, биелэлтийг нэгтгэн хүргүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | - | Хэрэгжилтийн хувь | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр 98,5 хувьтай хэрэгжсэн. | 2025 оны ХТТШ-ийн хэрэгжилт 95 хувиас доошгүй байна. | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн бүртгэл хөтөлж 2025 оны эхний хагас жилийн байдлаар Монгол улсын 4 хуулийн 39 заалт, УИХ-ын 4 тогтоолын 10 заалт, Засгийн газрын 17 тогтоолын 37 заалт, Засгийн газрын 28 хуралдааны тэмдэглэлийн 55 заалт, Засгийн газрын 3 албан даалгаврын 16 заалт, Ерөнхий сайдын 1 албан даалгаврын 1 заалт, Эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн 16 тогтоолын 56 заалт, Эрүүл мэндийн сайдын 7 тушаалын 21 заалт, Эрүүл мэндийн сайдын 3 албан даалгаврын 9 заалт нийт 73 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 244 заалтыг хяналтад авч, ЗГ-ын 2025 оны 43 дугаар тогтоолын дагуу 7 сарын 1-ний дотор ЭМЯ-нд хүргүүлэхээр хэрэгжилтийг нэгтгэж байна.<br>***Үр дүн:*** Хэрэгжилтийг холбогдох газарт хүргүүлэхээр бэлтгэж байна. | 50 |
| 1.4.11 | Бодлогийн баримт бичгийн тус газарт хамааралтай заалтын хэрэгжилтийг хангуулж, хяналт-шинжилгээ үнэлгээ хийлгэн холбогдох байгууллагад хүргүүлнэ. | - | Хэрэгжилтийн хувь | “Алсын хараа 2050”, МУХТҮЧ, ЗГҮАХ, ЭМДЕГ-ын Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг | Бодлогийн баримт бичгийн тайланг тогтоосон хугацаанд гаргаж холдогдох байгууллагад хүргүүлсэн байна. | Тайлагнах хугацаа болоогүй. | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | нэгтгэн ЭМЯ-нд хүргүүлсэн. | | | |
| **Зорилго 2. Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлогыг нэмэгдүүлж, үзүүлэх тусламж, үйлчилгээний тоо хэмжээ, хүрээг өргөтгөнө.** | | | | | | | |
| Зорилт 2.1.Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлого, тусламж, үйлчилгээний тоо хэмжээ нэмэгдүүлнэ | | | | | | | |
| 2.1.1 | *БГТ-2.1.2*<br>Капитал банк ХХК-ийн эрх хүлээн авагчаас шилжиж ирсэн үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах, эдийн засгийн эргэлтэд оруулах, шилжүүлэх ажлыг зохион байгуулж, эрх зүйн баримт бичгийг боловсруулна. | - | ЭМДС-д төвлөрсөн орлогын дүн | ЭМД-ын санд 1,088,441,632 төгрөгийн орлого төвлөрсөн. | Ажлын хэсэг байгуулж, үр дүнг тооцсон байна. | Капитал банк ХХК-ийн эрх хүлээн авагчаас ЭМДСангийн өр төлбөрт хүлээн авсан хөрөнгүүдийг худалдан борлуулах ажлыг эрчимжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг 2025 оны А/06 дугаар тушаалаар байгуулж, төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэ хүрээнд Капитал банк ХХК-ийн эрх хүлээн авагчаас ЭМДСангийн өр төлбөрт хүлээн авсан хөрөнгүүдэд дахин үнэлгээ хийлгэх ажлыг эхлүүлээд байна. Үнэлгээний дүнд үндэслэн дахин дуудлага худалдаа зохион байгуулахаар төлөвлөж байна. Мөн хөрөнгийг худалдан авах санал ирүүлсэн байгууллага, иргэний санхүүгийн чадавхийн тайланг хүлээн авч, судалсан.<br>***Үр дүн:*** Өр барагдуулах үйл ажиллагааг эрчимжүүлж, ЭМД сангийн мөнгөн хөрөнгийг нөхөн бүрдүүлж байна. | 100 |
| 2.1.2 | Чингис хаан банк ХХК, "Үндэсний хөрөнгө оруулалтын банк" ХХК-нд холбогдох мөнгөн авлага барагдуулах ажлыг эрчимжүүлж, цаашид авах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ. | - | Хэрэгжүүлсэн ажлын тоо | - | ЭМДЕГ, НДЕГ, Хөгжлийн банктай хамтарсан ажлын хэсэг байгуулж, үр дүнг тооцсон байна. | Чингис хаан банк ХХК, ҮХОБ-нд холбогдох авлага барагдуулах ажлын хэсгийн төлөвлөгөө батлуулж, төлөвлөгөөний дагуу ШШГГ-ын ахлах шийдвэр гүйцэтгэгч, Чингис хаан банк ХХК, ҮХОБ-ны шийдвэр гүйцэтгэгч нартай хамтарсан уулзалт зохион байгуулж ажиллалаа. Түүнчлэн ШШГЕГ-тай банкны өр барагдуулах чиглэлээр хамтарсан санамж бичгийг байгуулж, үйл ажиллагааг эрчимжүүллээ. Мөн өр барагдуулалтын байдал, цаашид авах | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | арга хэмжээний талаар Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн хуралдаанд тусгайлан асуудал боловсруулан танилцуулж, тодорхой асуудлаар чиглэл авсан. Тайлант хугацаанд нийт 30.8 тэрбум төгрөгөөс 935,280,898 төгрөг барагдуулаад байна.<br>***Үр дүн:*** Банкны өр барагдуулах үйл ажиллагааг эрчимжүүлж, ЭМД сангийн мөнгөн хөрөнгийг нөхөн бүрдүүлж байна. | |
| **Зорилго 3: Тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, худалдан авах үйл ажиллагааг хялбарчилна.** | | | | | | | |
| Зорилт 3.2.Даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарт холбогдох стандарт, эмнэлзүйн удирдамж, журмын дагуу хяналт тавьж, тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулна. | | | | | | | |
| 3.2.1 | *ЗГҮАХ-4.2.7, БГТ-3.2.6*<br>Жендерийн салбар зөвлөлийн 2025 оны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулна. | - | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | Жендерийн салбар зөвлөлийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилт 95 хувьтай хэрэгжсэн. | Төлөвлөгөөний хэрэгжилтийг 95 хувиас доошгүй хангуулсан байна. | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Жендэрийн салбар зөвлөлийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлуулж, 2025 оны төлөвлөгөөг Жендэрийн үндэсний хороо, ЭМЯ-ны салбар зөвлөлийн 2025 оны төлөвлөгөөтэй уялдуулан, 4 зорилт, 14 арга хэмжээтэйгээр боловсруулан батлууллаа. Төлөвлөгөөний дагуу Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын албан хаагчдад жендэрийн талаарх ойлголт, жендэрийн тэгш байдлын ач холбогдлын тухай сургалт зохион байгууллаа.<br>***Үр дүн:*** Жендэрийн салбар зөвлөлийн 2025 оны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангуулж байна. | 80 |
| 3.2.2 | БГТ-3.2.4<br>Орон нутаг дахь эрүүл мэндийн даатгалын зарим хэлтсийн үйл ажиллагаанд иж бүрэн хяналт шалгалт, хяналт шинжилгээ хийж, зөвлөн туслана. | - | Хяналт шалгалт, хяналт шинжилгээ хийсэн байна. | - | Өвөрхангай аймаг, Налайх, Багануур, дүүрэг дэх ЭМДХ-ийн үйл ажиллагаанд иж бүрэн хяналт шалгалт, хяналт | ЭМДЕГ-ын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 09 дүгээр сард зөвлөн туслах баг ажиллахаар төлөвлөсөн. | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шинжилгээ хийгдсэн байна. | | |
| **Зорилго 4. Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг төрийн захиргааны нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангана.** | | | | | | | |
| Зорилт 4.1. Хүний нөөцийн менежментийг байгууллагын онцлог, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлж, суралцагч байгууллага болон хөгжинө. | | | | | | | |
| 4.1.1 | *БГТ-4.1.1* Байгууллагын болон албан тушаалын чиг үүрэгт хяналт шинжилгээ хийнэ. | - | Хяналт шинжилгээ ний дүн | Чиг үүргийн шинжилгээний дүнг үндэслэн зохион байгуулалтын холбогдох арга хэмжээ авсан. | Чиг үүргийг оновчтой хуваарилж, ажлын үүргийг тэнцвэржүү-лсэн байна. | Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/556, ЭМДҮЗ-ийн 2020 оны 17 дугаар тогтоолыг үндэслэн баталсан бүтэц зохион байгуулалт чиг үүргийг дахин боловсруулж байгууллагын бүтцийн зураглалыг шинэчлэн гаргаж удирдлагад танилцуулаад байна. ***Үр дүн:*** Байгууллагын бүтцийн зураглалыг удирдлагад танилцуулаад байна. | 50 |
| 4.1.2 | *БГТ-4.1.1* Албан тушаалын тодорхойлолт шинээр боловсруулах, өөрчлөлт оруулах санал гаргаж холбогдох байгууллага, албан тушаалтнаар шийдвэрлүүлнэ. | - | ТАЗ-ийн шийдвэр | Төрийн албаны зөвлөлийн тогтоолоор 2022 онд батлуулсан. | Төрийн албаны зөвлөлийн хуралдаан-аар хэлэлцүүлэн зөвшөөрүүлж, батлуу-лсан байна. | ЭМДЕГ-ын төрийн захиргааны 238 албан хаагчид хамаарах 59 албан тушаалын тодорхойлолтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг хийж гүйцэтгэн ТАЗ-өөр баталгаажуулахад бэлэн болгоод байна. ***Үр дүн:*** ТАЗ-өөр баталгаажуулахад бэлэн болсон. | 50 |
| 4.1.3 | *БГТ-4.1.1* Бүтэц, зохион байгуулалт, ажлын байрны жагсаалтыг шинэчлэн боловсруулж батлуулна. | - | Эрүүл мэндийн сайд, ЭМДҮЗ, ЭМДЕГ-ын даргын шийдвэр | Бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийсэн байна. | Оновчтой бүтэц, зохион байгуулалт хийгдсэн байна. | Албан хаагчдын ажлын чиг үүргийг оновчтой хуваарилах, ачааллын тэнцвэртэй байдлыг хангах зорилгоор Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын “ЭМДЕГ-ын бүтцийн нэгжүүдийн албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” А/11 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан. ***Үр дүн:*** Ажил, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн боловсруулсан. | 100 |
| 4.1.4 | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллана. | - | Хэрэгжилт ийн хувь | Хөтөлбөрийн хэрэгжилт 100 хувь. | 98 хувиас доошгүй. | Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг бүрдүүлэлтийг хуулийн хугацаанд 100 хувь зохион байгуулж, тайланг 2025 оны 01/514 дугаар албан бичгээр АТГ-д хүргүүллээ. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүрээнд төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ЭМЯ-д хүргүүллээ. ***Үр дүн:*** Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хуулийн хугацаанд хүргүүлсэн. | |
| 4.1.5 | *БГТ-4.1.2* Эрүүл мэндийн даатгалын улсын байцаагчийн мэргэшлийн зэрэг тогтоох, зэргийн нэмэгдэл олгох журмын төсөл шинэчлэн боловсруулж Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолоор батлуулна. | - | Батлагдсан тогтоол | Эрүүл мэндийн даатгалын улсын байцаагчийн мэргэшлийн зэрэг тогтоох, зэргийн нэмэгдэл олгох журмын төсөл боловсруулсан. | Журмыг батлуулсан байна. | Эрүүл мэндийн даатгалын улсын байцаагчийн мэргэшлийн зэрэг тогтоох, зэргийн нэмэгдэл олгох журмын төсөл шинэчлэн боловсруулж Эрүүл мэндийн яам, Сангийн яамнаас албан бичгээр санал авсан. Сангийн яамнаас журмын төслийг дэмжих боломжгүй гэх хариу ирүүлсэн тул ЭМДҮЗ-өөр хэлэлцүүлж, эцэслэн шийдвэрлүүлэхээр ажиллаж байна. **Үр дүн:** Журмын төслийг ЭМДҮЗ-өөр хэлэлцүүлэхэд бэлэн болгосон. | **80** |
| 4.1.6 | *ЗГҮАХ-2.1.9, БГТ-4.1.3* Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг хангуулна. | - | Батлагдсан хөтөлбөрийн Хэрэгжилтийн хувь | 2024 онд Нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувь. | Хөтөлбөр батлагдаж, хэрэгжилт 92 хувиас доошгүй байна. | ЭМДЕГ-ын даргын 2023 оны А/174 дүгээр тушаалаар албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг үе шаттай зохион байгуулж байна. Үүнд: Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох дүрэм, журам, ЭМДЕГ-ын Хөдөлмөрийн дотоод журмын дагуу 2025 оны эхний 5 сарын дүнгээр 14 албан хаагчид нийт 11,1 сая төгрөгийн буцалтгүй тусламж, тэтгэмжийг олгов. ЭМДЕГ-ын даргын 2025.02.24-ний А/29 дүгээр тушаалаар сар шинийн баярын өдрийг тохиолдуулан байгууллагын 26 ахмад настанд тус бүр 200,000 төгрөгийн урамшуулал олгож, хүндэтгэл үзүүллээ. 2025 оны 05 дугаар сарын дүнгээр 21 ажилтанд үр хүүхэд, гэр бүлийн гишүүнээ асрах, эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамрагдах, суралцах, ар гэрийн гачигдал зэрэг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шалтгаанаар ажлын 3-23 өдрийн цалинтай /цалингүй/ чөлөө олгох асуудлыг шийдвэрлэлээ.<br>***Үр дүн:*** Нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулан ажиллав. | |
| 4.1.7 | *БГТ-4.1.4*<br>Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын ажилтнуудын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх богино хугацааны төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжүүлнэ. | - | Батлагдсан төлөвлөгөө | 2024 онд 2 бүлэг, 35 заалт бүхий сургалтын төлөвлөгөө батлан хэрэгжүүлсэн. | Богино хугацааны сургалтын төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувиас доошгүй байна. | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2023 онд батлагдсан "Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр"-т заасны дагуу 2025-2026 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 5 зорилт, 27 арга хэмжээний хүрээнд 2025 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөг 2 зорилт, 32 арга хэмжээг зохион байгуулахаар батлуууллаа. Тайлант хугацаанд нийт 23 удаагийн сургалтад 876 албан хаагчид хамрагдаад байна.<br>***Үр дүн:*** Сургалтын төлөвлөгөө батлагдаж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | 100 |
| 4.1.8 | *БГТ-4.1.5*<br>Ажилтнуудын ажлын үр дүн, бүтээмжийг үнэлэх ажлыг зохион байгуулж, шагнал, урамшуулал, сахилга хариуцлагын механизмтай уялдуулна. | - | -Журмын хэрэгжилт<br>-Урамшуулал олгогдсон албан хаагчдын тоо | Журмын дагуу 187 албан хаагчид 2 удаа бүтээмжийн урамшуу-лал олгогдсон. | -Урамшуулал олгогдсон байна.<br>-Урамшуулал олгох дээд, доод хязгаар, аргачлал баталсан ЭМДЕГ-ын даргын тушаалд өөрчлөлт оруулсан байна. | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/53 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг ажиллаж 180 албан хаагчид бүтээмжийн урамшуулал олгосон.<br>***Үр дүн:*** 2025 оны эхний ээлжийн урамшуулал олгогдсон. | 100 |
| 4.1.9 | Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийн хүрээнд байгууллагын хөдөлмөрийн харилцааг зохион байгуулна. | - | Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь | Хууль тогтоомжийн хэрэгжилт 98,4 хувь хэрэгжсэн. | Хууль тогтоомжийн хэрэгжилт 95 хувиас доошгүй байна. | Тайлант хугацаанд иргэд, албан хаагчдаас ирүүлсэн хөдөлмөрийн харилцаатай холбоотой 116 өргөдөл, дээд шатны болон харилцагч байгууллагаас ирүүлсэн 44 албан бичгийг холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэн ажиллалаа.<br>Мөн ЭМДЕГ-ын даргын тушаалын хүрээнд дараах хүний нөөцийн үйл ажиллагааг зохион байгууллаа. Үүнд: | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Өөр байгууллагаас шилжин томилогдсон 4, шинээр ажилд томилсон 3, өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн 4, өөр байгууллагад шилжин томилогдсон 2, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн 6, хүүхэд асрах чөлөөнөөс ажилдаа томилогдсон 3, сахилгын шийтгэл ногдуулсан 1, ээлжийн амралтын хуваарьт өөрчлөлт оруулсан, амралт олгосон 9, чөлөө (цалинтай, цалингүй ажлын 3-23 өдөр) олгосон 21, нэг удаагийн буцалтгүй тусламж, тэтгэмж олгосон 14, албан үүрэг түр орлон гүйцэтгүүлсэн 10, албан үүрэг түр орлон гүйцэтгүүлэх хугацааг дуусгавар болгосон 5 байна. 2025 оны ээлжийн амралтын хуваарийг А/03 дугаар тушаалаар батлуулж, 2025 оны 1-7 дугаар сард ээлжийн амралтаа эдлэх 122 ажилтны ээлжийн амралтын мэдэгдлийг бичиж, тооцоо хийлгэхээр санхүүд шилжүүллээ. ***Үр дүн:*** Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. | |
| 4.1.10 | Албан хаагчдын хувийн хэргийг журмын дагуу бүрдүүлж, тухай бүр баяжуулан, шаардлагатай мэдээ, судалгааг гаргаж, удирдлагыг мэдээллээр хангана. | - | Статистик мэдээллийн төрөл (тоогоор) | 43 төрлийн мэдээ, судалгаа гаргасан | Албан хаагчдын талаарх судалгаа мэдээллийг гарган, нэгтгэсэн байна. | Хүний нөөцийн мэдээллийн оновчтой менежмент, бодлого боловсруулах, шийдвэр гаргалтыг тоон үндэслэлтэй болгох зорилгоор 2025 онд нийт 34 төрлийн судалгааг шинэчлэн боловсруулж, баяжилт хийлээ. Үүнд: Ажилласан жилийн судалгаа (улс, төрийн алба), орон сууц, жирэмсний болон хүүхэд асрах чөлөөтэй албан хаагчид, ахмадын судалгаа, шагналын, боловсролын, төрийн захиргааны зэрэг дэв, ЭМД-ын улсын (ахлах) байцаагч гэх мэт. Эдгээр судалгааг улирал тутам шинэчилж, төлөвлөлт, тайлагналт, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүний нөөцийн стратеги бодлогын үндэс болгон ашиглаж байна. ***Үр дүн:*** Албан хаагчдын талаарх судалгаа мэдээллийг гаргаж нэгтгэсэн. | |
| 4.1.11 | Хүний нөөцийн цахим системийг хөтөлнө. | - | Цахим системийн бүрдүүлэлт | Нийт ажилтнуудын мэдээллийг цахим системд бүртгэсэн | Нийт ажилтнуудын мэдээлэл цахим системд бүртгэгдэж, зохих өөрчлөлт хийгдсэн байна. | Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан ЭМДЕГ-ын даргын 2025 оны А/04 дүгээр тушаалаар 178 албан хаагчийн цалинг шинэчлэн батлуулж, ХНУМТ цахим системд цалинг ажилтан тус бүрээр шивж баталгаажуууллаа. Төрийн албаны зөвлөлийн цахим системд төрийн албан хаагчийн анкетыг цахимжуулах ажлын хүрээнд газар, хэлтсүүдийн хуваарийг боловсруулсан.<br>186 албан хаагчийн үндсэн мэдээлэл хэсэгт ажилласан жил, төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, сахилгын шийтгэл, хөдөлмөрийн чадвар алдалтын хугацаа, хувь тогтоолгосон акт, төрийн дээд болон салбарын шагналын мэдээллийг шивж баяжилтыг хийлээ. Мөн 2025 онд тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан 8 албан хаагчийн ажилласан жилийн мэдээллийг ХНУМТ цахим системд тулгалт хийж, холбогдох шийдвэрийг оруулж баяжилт хийв.<br>"Able" системд шинээр болон шилжүүлэн томилогдсон, чөлөөлөгдсөн албан хаагчдын бүртгэл мэдээллийг тухай бүр шивж, бүртгэлийг хөтөлж хэвшсэн. Тайлант хугацаанд ээлжийн амралт, сургалт, томилолт, гадуур ажил, өвчтэй болон хувийн шалтгаанаар чөлөө авсан албан хаагчдын чөлөөний хуудсыг тухай бүр хүлээн авч, системд 878 удаагийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төлөвийг шивж оруулав. Мөн 14 хоног тутамд албан хаагчдын ажлын цагийн бүртгэлийн төлөвийг татаж, хяналт тавин ажиллаж байна.<br>***Үр дүн:*** Хүний нөөцийн цахим системийн баяжилтыг тогтмол хийж гүйцэтгэлээ. | |
| 4.1.12 | Зохих болзол, шалгуур хангасан төрийн захиргааны албан хаагч нарт албан тушаалын зэрэг дэв олгуулах санал боловсруулж шийдвэрлүүлнэ. | - | Шинээр зэрэг дэв олгогдсон албан хаагчийн тоо | 10 албан хаагчид шинээр, 42 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулан олгосон. | Албан хаагчдын зэрэг, дэвийн судалгаа хийж, холбогдох газарт санал хүргүүлэн шийдвэрлүүлсэн байна. | ЭМДЕГ-ын даргын 2025.02.07-ны өдрийн 01/339 албан бичгээр журмын шалгуур хангасан 61 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулах, 23 албан хаагчид шинээр зэрэг дэв олгуулахаар Төрийн албаны зөвлөлийн ЭМЯ-ны дэргэдэх салбар зөвлөлд уламжиллаа.<br>Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/66 дугаар тушаалын дагуу ЭМДЕГ-ын 2025 оны А/39 дүгээр тушаалаар төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв шинээр болон ахиулан олгосон 39 албан хаагчийн цалинг шинэчлэн тогтоож, шийдвэрийг ХНУМТ цахим системд шивж баталгаажуулсан. Журмын дагуу төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв 2020-2025 оны хугацаанд шинээр зэрэг дэв 67, ахиулан олгуулсан давхардсан тоогоор 136 буюу нийт 203 албан хаагчийн зэрэг дэвийг шийдвэрлүүлж, цалингийн зохих нэмэгдлийг тухай бүр шийдвэрлэн ажилласан.<br>***Үр дүн:*** 84 албан хаагчдын зэрэг дэвийн судалгаа хийж, санал хүргүүллээ. | 100 |
| 4.1.13 | Эрүүл мэндийн даатгалын улсын (ахлах) байцаагчдын эрх олгох, цуцлах, түдгэлзүүлэх, үнэмлэх, тэмдэг, хяналт шалгалтын хэвлэмэл хуудас хийлгэх | - | Улсын байцаагчийн эрхтэй албан хаагчийн тоо | Эрүүл мэндийн даатгалын улсын (ахлах) 97 байцаагч холбогдох хууль тогтоомжийн дагуу чиг үүргээ | Улсын (ахлах) байцаагчийн эрх олгох, цуцлах, түдгэлзүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна. | ЭМДЕГ-ын хэмжээнд улсын (ахлах) байцаагчийн судалгааг шинэчлэн гаргаж, ЭМД-ын улсын ахлах байцаагч-30, ЭМД-ын улсын байцаагч-54 буюу нийт 84 байцаагч холбогдох хууль тогтоомжийн дагуу чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна. ЭМД-ын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | | | хэрэгжүүлэн ажиллаж байна. | | улсын /ахлах/ байцаагчийн эрхийг цуцалсан-14 албан хаагч, ЭМД-ын улсын /ахлах/ байцаагчийн эрх олгох албан хаагчдын судалгаа-16 байгаагаас ЭМДЕГ-ын даргын 2025 оны А/66 дугаар тушаалаар 15 албан хаагчид Эрүүл мэндийн даатгалын улсын байцаагчийн эрхийг олгов. ***Үр дүн***: 15 албан хаагчид улсын (ахлах) байцаагчийн эрх олгож, 14 улсын (ахлах) байцаагчийн эрх цуцалсан байна. | |
| 4.1.14 | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын шуурхай хурлын бэлтгэлийг хангаж, зохион байгуулалт, хэрэгжилтийг хариуцан тайлагнана. | - | Зохион байгуулагдсан шуурхайн тоо, хэрэгжилтийн хувь | Нийт 22 удаагийн шуурхай хурлын бэлтгэл, зохион байгуулалтыг хангаж ажилласан. | Хурлын бэлтгэл, зохион байгуулалтыг хангаж, хэрэгжилтийг тайлагнасан байна. | Хагас жилийн байдлаар газрын шуурхай хурлыг нийт 16 удаа зохион байгуулж, хурлаас 151 өгөгдсөн үүрэг даалгаврыг байнга хэрэгжүүлэх, цаг үеийн шинжтэй болон нэг удаагийн хэрэгжүүлэх үүрэг даалгаврын хэрэгжилтийг 100 хувь биелэлтийг газар хэлтсийн дарга нараар гаргуулж, тухай бүр удирдлагад танилцуулж ажиллалаа. ***Үр дүн:*** Шуурхай хурлын үүрэг даалгаврын биелэлтийн хэрэгжилтийг тайлагнасан. | 100 |
| 4.1.15 | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын зөвлөлийн хурлын бэлтгэлийг хангаж, зохион байгуулалт, хэрэгжилтийг хариуцан тайлагнана. | - | Зохион байгуулагдсан хурлын тоо, хэрэгжилтийн хувь | Нийт 5 удаагийн даргын зөвлөлийн хурлын бэлтгэл, зохион байгуулалтыг хангаж ажилласан. | Хурлын бэлтгэл, зохион байгуулалтыг хангаж, хэрэгжилтийг тайлагнасан байна. | 2025 онд Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын хурлаар 25 асуудал хэлэлцүүлэхээр төлөвлөгөө батлагдсан ба тайлант хугацаанд хуралдааныг 2 удаа зохион байгуулсан байна. 1-р хурлаар 3 асуудал, 2-р хурлаар 3 асуудал хэлэлцэгдлээ. Тус 2 удаагийн хурлын протоколыг хөтлөн, хурлын шийдвэрийг албажуулж, Эйбл цахим системд байршуулж, хэрэгжилтийг хангуулλаа. ***Үр дүн***: Газрын зөвлөлийн хурлыг зохион байгуулж ажиллаа. | 100 |
| 4.1.16 | “Иргэдтэй уулзах өдөр”-ийг хуваарийн дагуу зохион байгуулна. | - | Батлагдсан хуваарь | ЭМДЕГ-ын даргын А/148 дугаар | | Иргэдтэй уулзах өдрийн хуваарийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргаар батлуулж, газар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | тушаалаар иргэдтэй уулзах өдрийн удирдамж, хуваарийг баталж хэрэгжүүлсэн. | Улирал бүрийн хуваарь батлагдан мөрдөгдсөн байна. | хэлтсийн дарга нар хуваарийн дагуу иргэдийг хүлээн авч уулзан, асуудлыг газар дээр нь шийдвэрлэн ажиллаж байна. | |
| 4.1.17 | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллана. | - | Өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт | Өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажилласан. | Өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажилласан байна. | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн холбогдох и-мэйл болон хурал, уулзалтыг зохион байгуулан ажиллаж байна. Мөн тухай бүр тушаал, шийдвэрийг гарган ажиллалаа. ***Үр дүн:*** Газрын даргын өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. | 100 |
| 4.1.18 | *БГТ-4.1.7* Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын ажилтнуудад зориулсан цахим гарын авлагын гаргаж, мэдээллийг тухай бүр шинэчилнэ. | - | Цахим эмхэтгэлд хандсан хандалтын тоо | Цахим гарын авлага бэлтгэсэн. | Цахимжсан гарын авлагын гаргаж, мэдээллийг тухай бүр шинэчилсэн байна. | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын ажилтнуудад зориулсан дотоод үйл ажиллагаандаа ашиглах Ерөнхий газрын бүтэц, чиг үүргийн хүрээнд мөрдөгдөх дүрэм, журмыг агуулсан гарын авлагыг боловсруулж цахим хэлбэрт оруулан тухай бүрд мэдээллийг шинэчлэн цахим системд байршуулсан. ***Үр дүн:*** Гарын авлагыг Эрүүл мэндийн даатгалын цахим хуудсанд байршуулсан. | 100 |
| 4.1.19 | Байгууллагын архивт хадгалах хугацаа дууссан баримтыг харьяалах төрийн архивын дэргэдэх БНШАЗК-ын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж устгах ажлыг зохион байгуулна. | - | Устгасан баримтын тоо | - | Байгууллагын архивт хадгалах хугацаа дууссан устгах баримтын жагсаалтыг гаргаж зохих журмын дагуу устгасан байна. | Архивын ерөнхий газрын даргын “Байгууллагын үйл ажиллагаанд үүссэн удирдлагын нийтлэг баримт бичгийн хадгалах хугацааны үлгэрчилсэн жагсаалт батлах тухай” 2007 оны 160 дугаар тушаал, “Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалт батлах тухай” 2023 оны А/91 дүгээр тушаалаар шинэчлэгдсэн батлагдсан жагсаалт, ЭМДЕГ-ын “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт”-ыг тус тус үндэслэн Эрүүл | **50** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэндийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны явцад үүссэн хадгалах хугацаа нь дууссан, архивын санд хадгалах шаардлагагүй болсон 2003-2023 онд хамаарах 23 нэр төрлийн нийт 1716 (нэг мянга долоон зуун арван зургаа) боть баримтад устгах акт үйлдэж байгууллагын дэргэдэх Баримт нягтлан шалгах комиссын хурлаар хэлэлцүүлэхээр төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг зохион байгууллаа. ***Үр дүн:*** Устгах баримтын актыг байгууллагын дэргэдэх БНШК-ын хурлаар хэлэлцүүлж батлуулсан. | |
| 4.1.20 | Байнга, түр, 70 жил хадгалах хадгаламжийн нэгжийн данс, бүртгэл үйлдэж харьяалах төрийн архивын дэргэдэх БНШАЗК-ын хурлаар хэлэлцүүлж батлуулна. | - | Батлагдсан жагсаалт | - | Байгууллагын архивт хадгалагдаж байгаа хадгаламжийн нэгжид данс, бүртгэл үйлдсэн байна. | Архивын ерөнхий газрын даргын "Байгууллагын үйл ажиллагаанд үүссэн удирдлагын нийтлэг баримт бичгийн хадгалах хугацааны үлгэрчилсэн жагсаалт батлах тухай" 2007 оны 160 дугаар тушаал, "Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалт батлах тухай" 2023 оны А/91 дүгээр тушаалаар шинэчлэгдсэн батлагдсан жагсаалт, ЭМДЕГ-ын "Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт"-ыг тус тус үндэслэн байгууллагын архивд хадгалагдаж буй 2011-2024 онд хамаарах байнга, түр, 70 жил хадгалах хадгаламжийн нэгжид данс, бүртгэл үйлдэж байгууллагын дэргэдэх Баримт нягтлан шалгах комиссын хурлаар хэлэлцүүлэхээр төлөвлөгөөг батлуулсан. ***Үр дүн:*** Комиссын хурлын төлөвлөгөөг батлууллаа. | **100** |
| 4.1.21 | Байгууллагын хэмжээнд хэрэглэгдэж байгаа хэвлэмэл хуудасны загварыг Архивын ерөнхий газраар батлуулж, | - | Хэвлүүлсэн хэвлэмэл хуудасны тоо | Байгууллагын хэмжээнд 34,700 ширхэг хэвлэмэл хуудсыг Архив, албан хэрэг | Зохион байгуулалтын нэгжийн үйл ажиллагаанд хэрэглэгдэж байгаа | Төв аппарат болон аймаг, дүүрэг дэх Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн үйл ажиллагаанд хэрэглэгдэж байгаа албан бичгийн (кирилл болон монгол бичгийн) болон хяналт шалгалтын хэвлэмэл | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэвлүүлэх, орон нутаг дахь нэгжүүдэд хүргүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | | | хөтлөлтийн хууль, тогтоомж, журам, стандартын дагуу хэвлүүлж, хүргүүлсэн. | хэвлэмэл хуудасны захиалгыг авч, хэвлүүлэн, нэгжүүдэд хүргүүлсэн байна. | хуудсын загварыг Архивын ерөнхий газрын архив, албан хэрэг хөтлөлтийн улсын байцаагчаар мэдээлэл бүрэн, зөв эсэхийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хянан баталгаажуулсан бөгөөд хэвлүүлэх зөвшөөрөл авсан.<br>***Үр дүн:*** Байгууллагын хэмжээнд 7,810 ширхэг хэвлэмэл хуудсыг Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль, тогтоомж, журам, стандартын дагуу хэвлүүлж, хүргүүлсэн. | |
| 4.1.22 | Байгууллагын “Архивын журам”-ыг шинэчлэн батлуулна. | - | Батлагдсан журам | ЭМДЕГ-ын даргын 2022 оны А/128 дугаар тушаалаар “Архивын журам”-ыг баталж хэрэгжүүлсэн | Журмыг шинэчлэн батлуулж, мөрдүүлсэн байна. | Хөтлөгдөж дууссан цахим албан хэргээр архивын нэгж бүрдүүлэх, байгууллагын архивд хүлээн авах цахим архивын журмын төслийг боловсруулж байна.<br>***Үр дүн:*** Хэрэгжих шатандаа | 50 |
| 4.1.23 | Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, заавры г байгууллагын хэмжээнд хэрэгжүүлж, холбогдох зохион байгуулалтаар хангаж ажиллана. | - | Архивын нэгж бүрдүүлэлтийн тоо (Боть) | 2023 онд нийт 725 (долоон зуун хорин тав) боть баримтыг хүлээн авсан. | Хөтлөх хэргийн жагсаалт, баталсан хуваарийн дагуу байгууллагын архивт нөхөн бүрдүүлэлт хийсэн байна. | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт, тоо хэмжээг үндэслэн өмнөх онд шийдвэрлэгдсэн баримт хүлээн авах хуваарийг боловсруулж, батлуулсан. Байгууллагын зохион байгуулалтын нэгж, ажилтан нь албан хэрэг хөтлөлтийн шатанд шийдвэрлэгдэж дууссан баримт бичгүүдийг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу ангилан төрөлжүүлж, Засгийн газрын 2024 оны 214 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын 6.20, 6.21-д заасан шаардлагад нийцүүлэн архивд шилжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллалаа.<br>2025 оны 01 дүгээр улиралд зохион байгуулалтын нэгж, ажилтнаас 143 нэр төрлийн баримт бичгүүдийг батлагдсан хуваарийн дагуу байгууллагын архивт шилжүүлэх ба зохион байгуулалтын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нэгж, ажилтнаас бүрэн бүрдэл бүхий 828 (найман зуун хорин найм) боть баримтыг хүлээн авч, байгууллагын архивд баяжуулалт хийлээ. Үүнд:<br>Байнгын хадгалах - 31 боть буюу 3,7%<br>Түр хадгалах – 778 боть буюу 93,9%<br>70 жил хадгалах -19 боть буюу 2,3%<br>***Үр дүн:*** Бүрэн бүрдэл бүхий 828 боть баримт хүлээн авсан. | |
| 4.1.24 | | | Нийт албан бичиг, өргөдөл гомдлын тоо, шийдвэрлэлтийн хувь | 12759 албан бичиг, өргөдөл гомдлыг хүлээн авч, 96,13 хувьтай шийдвэрлэсэн | Албан бичиг, өргөдөл гомдлыг хүлээн авч, бүртгэн шийдвэрлэлтэд хяналт тавьж, тайлагнан ажилласан байна. | Тайлант хугацаанд 2553 албан бичиг хүлээн авснаас шийдвэрлэсэн нь 2067, хяналтад байгаа 199, хариутай 2267, хариугүй 287, хугацаа хэтэрсэн байхгүй, шийдвэрлэлт 91.13 хувьтай байна. 1078 өргөдөл хүлээн авснаас шийдвэрлэсэн нь 1014, хяналтад байгаа 64, хариутай нь 1078, хугацаа хэтэрсэн өргөдөл байхгүй, шийдвэрлэлт 93.98 хувьтай байна.<br>***Үр дүн:*** Чиг үүргийн дагуу өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна. | 100 |
| 4.1.25 | Байгууллагын “Албан хэрэг хөтлөлтийн журам”-ыг шинэчлэн батлуулна. | - | Батлагдсан тушаал | ЭМДЕГ-ын даргын 2021 оны А/36 дугаар тушаалаар “Албан хэрэг хөтлөлтийн журам”-ыг баталж хэрэгжүүлсэн | Журмыг шинэчлэн баталуулж, мөрдүүлсэн байна. | Байгууллагын “Албан хэрэг хөтлөлтийн журам”-ын төслийг боловсруулж байна.<br>***Үр дүн:*** Журмыг боловсруулж байна. | 50 |
| 4.1.26 | Цахим гарын үсгийг байгууллагын үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлнэ. | - | Цахим гарын үсгээр албажсан албан бичгийн тоо | Байгууллагын хэмжээнд цахим гарын үсгээр 757 албан бичиг баталгаажуулсан | Цаасан хэлбэрт байгаа мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлэх, илгээх, хүлээн авах, хадгалах үйл ажиллагаанд цахим гарын үсэг нэвтрүүлсэн байна. | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын төв, орон нутгийн газар, хэлтсүүдэд цахим гарын үсгийг бүрэн нэвтрүүлж ажиллаа. Цахим гарын үсгээр нийт 399 албан бичиг илгээсэн байна.<br>***Үр дүн:*** Байгууллагын хэмжээнд гарын үсэг бүрэн цахимжсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.27 | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой санхүүгийн гүйлгээ хийж, орлого, зарлагыг тооцон тайлагнаж, архивлана. | - | Үйл ажиллагааны батлагдсан төсөв (мянган төгрөг) | Батлагдсан 15,912,525,400.00 төгрөгийн төсвийн хүрээнд өр төлбөргүй ажилласан | 15,700,867.2 төгрөгийн зарцуулалтыг зохих хууль тогтоомжийн хүрээнд зарцуулсан байна. | Тайлант хугацаанд 3,510,038,604.79 төгрөгийн гүйлгээг зохих хууль тогтоомжийн хүрээнд зарцуулсан байна. Үүнд: Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулалд 2,778,275,603.88, ажил олгогчоос нийгмийн даатгалын зардал-267,274,595.09, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 70,782,551.96, хангамж, бараа материалын зардалд 52,828,797.87, Эд хогшил, урсгал засварын зардалд 12,264,680.00, томилолт, зочны зардал 36,263,556.00, бараа үйлчилгээний бусад зардалд 44,646,478.77, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардалд 206,002,347.22, бусад нийтлэг АҮТХураамж 4,900,00, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал 18,400,0000 төгрөгийн зарцуулалт хийсэн байна.<br>***Үр дүн:*** Санхүүгийн өдөр тутмын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулсан. | 100 |
| 4.1.28 | Төв, орон нутаг дахь Эрүүл мэндийн даатгалын газар, нэгжийн үндсэн хөрөнгө, бараа материалын бүртгэл хөтлөн, хагас, бүтэн жилээр тооллого хийж, тооллогын дүнгээр холбогдох арга хэмжээг зохион байгуулна. | - | Тооллогын дүн (мөнгөн дүнгээр) | 2024 оны жилийн эцсийн үндсэн хөрөнгийн тооллогын дүн 13,8 тэрбум, бараа материалын тооллог-ын дүн 196 сая төгрөг | Хагас, бүтэн жилийн тооллого хийгдсэн байна. | Тайлагнах хугацаа болоогүй | - |
| 4.1.29 | Барилга байгууламжийн аюулгүй байдал, авто машины бэлэн байдал, цахилгаан, дулаан, сантехник, харуул хамгаалалтын өдөр тутмын | - | Цахилгаан, сантехник, цэвэрлэгээ үйлчилгээ, харуул | Тайлант хугацаанд үр дүнтэй ажилласан. | Байгууллагын харуул хамгаалалт, цэвэрлэгээ үйлчилгээг үр дүнтэй зохион | Байгууллагын жолооч, харуул хамгаалалт, цахилгаан, сантехник, цэвэрлэгээний өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар ханган, үйлчилгээний стандартыг мөрдүүлэн ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэвийн үйл ажиллагаа, нийтийг хамарсан арга хэмжээний зохион байгуулалтыг хариуцна. | | хамгаалалтын чанар -Зохион байгуулсан арга хэмжээний тоо | | байгуулан ажилласан байна. | ***Үр дүн:*** Байгууллагын өдөр тутмын хэвийн үйл ажиллагаа хангагдсан. | |
| 4.1.30 | Ажилтнуудад эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ, физик эмчилгээ үзүүлнэ. | - | Тусламж үйлчилгээний тоо | Албан хаагчидад давхардсан тоогоор 1492 удаагийн тусламж үйлчилгээ үзүүлсэн | Албан хаагчдад 1000-с доошгүй удаа тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. | Байгууллагын албан хаагчдад өдөр тутам эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тасралтгүй үзүүллээ. Тайлант хугацаанд хэсгийн бариа засал 86, бүтэн бариа 638, галын эмчилгээ 115, цахилгаан зүү 360, бумба үйлчилгээ 411 савны хийн бариа 20, хордлого 35, артерийн даралт хэмжих 178 удаа албан хаагчид үзүүлсэн дүнтэй байна.<br>***Үр дүн:*** Давхардсан тоогоор 1492 албан хаагчид эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлсэн. | 100 |
| 4.1.31 | Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн батлуулж, мөрдүүлнэ. | - | Батлагдсан төлөвлөгөө | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын гамшгаас хамгаалах 2020 оны төлөвлөгөө | Төлөвлөгөө баталж мөрдүүлсэн байна. | Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, Хан-Уул дүүргийн онцгой байдлын хэлтсийн холбогдох албан тушаалтанд хүргүүллээ.<br>***Үр дүн:*** Төлөвлөгөө хянуулах шатандаа байна. | 50 |
| 4.1.32 | Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр дүрэм, журмыг батлуулж мөрдүүлэх | - | Батлагдсан журам | - | Журам батлагдаж мөрдүүлсэн байна. | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2 зорилт, 14 арга хэмжээг зохион байгуулахаар батлууллаа. Агентлагийн хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын ажилтнуудын хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулж, 13 ажилтан тус бүрд (харуул, үйлчлэгч, сантехникч, жолооч) Хөдөлмөрийн гэрээнд чиглэл тус бүрээр аюулгүй ажиллагааны зааварчилгааг нарийвчлан тусгаж, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэрэгжилт үр дүнг тооцон ажиллаж байна.<br>***Үр дүн:*** Аюулгүй ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тооцон ажиллаж байна. | |
| | | | | | | **Дундаж гүйцэтгэлийн хувь:** | 90.68 % |

*Төлөвлөгөөг үнэлсэн:* ***Төсвийн шууд захирагч***

ДАРГА ............................ (С.ЭНХБОЛД)

............................
*(огноо)*

*Тайлагнасан:* ***Нэгжийн дарга***

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА ............................ (М.НАРМАНДАХ)

2025.05.28............
*(огноо)*